



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН  
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА  
Л.ЗОРИГ ТАНАА

2013.02.25 № 01/10 ЧАГ/САГ/2013/21/СТГА

Зөрчлийг арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2012 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэрт гарсан 5 ажилтны ажилласан жилийн судалгаа, хөдөлмөрийн дэвтэр болон НД-ын дэвтрийн баталгаажилт байхгүй, архивын лавлагаа байхгүй, зөвхөн тушаалаар 51.8 сая төгрөгийн тэтгэмж олгосон,
- Т.Нарантуяа, Саранцэцэг нарт олгосон сургалтын төлбөрт 2.2 сая төгрөгийг үндэслэх баримтгүйгээр карт руу нь шилжүүлсэн,
- Болормаа, Гэрэлцэцэг нарын гадаад томилолтын зардал 1.7 сая төгрөгийг үндэслэх баримтгүйгээр карт руу нь шилжүүлсэн,
- Саам сувилалд цахилгааны ажил хийсний хөлс 2.5 сая төгрөг, ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 1.7 сая төгрөг, гадны байгууллагын ажилтныг шагнахад 0.1 сая төгрөг

нийт 4.3 сая төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлж зардалд хаасан

Дээрх зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 7.4-д “ААНБ-ын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ.”, мөн хуулийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт

070025

тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

Үндэслэх баримтгүй олгосон 60.1 сая төгрөгийн холбогдох баримт материал, тайлан тооцоог бүрдүүлж зөрчлийг арилган, биелэлтийг 2013 оны 3 дугаар сарын 25-ны дотор багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дарга Л.Зориг, Ерөнхий нягтлан бодогч Ж.Отгонням нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГА

#### БИЧСЭН:

Үндэсний аудитын газрын  
Ахлах аудитор. Г.ЮРА  
  
Бодит бүртгэл Аудит ХХК-ийн  
Захирал 3.Ганболд  
БОДИТ БҮРТГЭЛ  
АУДИТ  
ХХК  
УЛААНбаатар хот

#### ТАНИЛЦСАН:

ТТАХНЭ-ийн дарга  
Л.ЗОРИГ  
  
Ерөнхий нягтлан бодогч  
Ж.Отгонням  
УХЕ0063